



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/69

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.4.3, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.14, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 13 дугаар зүйлийн 13.2, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.1.4.3-т хүүхэд, залуучуудад түүх, соёл, зан уламжлалаа гүнзгий таниулах, эх оронч үзлийг төлөвшүүлэх ажлыг нийгэм, гэр бүл, боловсролын тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлэх, мөн “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”ийн 3.2.14-т сурагчдын амьдрах ур ухааныг хөгжүүлэх, аюулгүй байдлын сургалтыг нэвтрүүлж, хүүхдийг эрсдэлгүй, осол эндэлгүй, эрүүл, аюулгүй амьдрах чадварт сургах зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн цэргийн байгууллагуудтай хамтран 2019 оны 07 дугаар сарын 23-ны өдрөөс 08 дугаар сарын 06-ны өдрүүдэд хүүхдийн зуны сургалтыг Батлан хамгаалах яамны харьяа “Шонхор” зусланд зохион байгуулсугай.

2. Сургалт зохион байгуулах алба хаагчдын нэрсийг нэгдүгээр, шаардлагатай зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт зохион байгуулахад шаардагдах 537,000 (таван зуун гучин долоон мянган) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

4. Хөтөлбөр, хуваарийн дагуу сургалтыг зохион байгуулж, сургалтын явцад хяналт тавьж, дүнг танилцуулахыг Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс (хурандаа Г.Нэргүй)-т тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (дэд хурандаа Н.Нямхорлоо)-д даалгасугай.

ДАРГА,  
ХУРАНДАА  Ж.ЧҮЛТЭМСҮРЭН




Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын  
2019 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн  
2/19 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ХҮҮХЭД БАГАЧУУДАД ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТЫН  
БАГИЙН АЛБА ХААГЧДЫН НЭРС

№	Овог нэр	Албан тушаал	Цол
1	Гомбо-Очир Нэргүй	Нийслэлийн Онцгой байдлын газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга	Хурандаа
2	Санжаашарав Должинсүрэн	Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Урьдчилан сэргийлэх, хэвлэл олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн	Ахлах дэслэгч
3	Пүрэвдорж Одонтуяа	Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Сургалт, урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн	Ахлах дэслэгч
4	Батбаатар Уянга	Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Сургалт, урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн	Ахлах дэслэгч

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын  
2019 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн  
9/69 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ХҮҮХЭД БАГАЧУУДАД ГАМШГААС УРЬДЧИЛАНСЭРГИЙЛЭХ  
МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТАД ШААРДЛАГАТАЙ СУРГАЛТЫН  
ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт үнэ /төг/	Тайлбар
Бичиг хэрэгслийн зардал						
1	Соронз /A4/	ширхэг	20	5000	100,000	Эвлүүлдэг соронзон карт хийхэд ашиглана.
2	Бичгийн цаас	боодол	6	11000	66,000	-
4	Наадаг өнгийн цаас	боодол	20	2800	56,000	Багаар ажиллахад самбар дээр нааж хэрэглэх
5	Плэй чартын цаас	боодол	20	8000	160,000	Багаар ажиллахад суралцагчид тэмдэглэл хийнэ.
6	Маркер	ширхэг	20	1000	20,000	-
7	Шохоотой цаас /40 гр/	боодол	10	6000	60,000	-
8	Ватом цаас	ширхэг	30	2500	75,000	-
Нийт дүн					537,000	

--o0o--